



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №41



2018 оны 12-р сарын 10-14

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1263** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 120(9.5%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1096(87%) хачигт халдвар, 25(2%) бэтэг, 2(0.1%) хумхаа, 10(0.8%) боом, 7(0.5%) тарваган тахал, ку чичрэг, татран, денгийн чичрэг өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол тус тус 1(0.1%) бүртгэгдээд байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1096** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13.9%-иар бага байна.



Хачигт риккетсиозын 816 сэжигтэй тохиолдлын 202(24.7%), хачигт энцефалитын 185 сэжигтэй тохиолдлын 32(17.3%), хачигт боррелиозын 95 сэжигтэй тохиолдлын 23(24.2%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдсан байна

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **120** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 24%-иар илүү байна. Эпидемиологийн 49-р долоо хоногтой харьцуулахад 4 сэжигтэй тохиолдлоор бага байна.




12 дугаар сарын 12-нд Ховд аймгийн ЗӨСТ-ийн өгсөн мэдээгээр:

Ховд аймгийн Буянт сумын харьяат Галт багийн “Эргэнэг” гэдэг газар 12 дугаар сарын 08-нд галзуугийн сэжигтэй чононд уруулсан. Өвчтөн “Б” 72 настай, эрэгтэй, малчин. Өвчтөн орчиндоо харьцаатай, нүүр, хүзүү орчимд урагдсан гүн шархтай. 12 дугаар сарын 08-нд Булган сумын НЭ-т шархны анхны цэгцлэлт хийлгэж, 8-нд эмнэлэгт хэвтсэн. Одоогоор галзуугийн эсрэг вакцины I, II-р тунд хамрагдаад байна. ЗӨСҮТ-өөс 12 дугаар сарын 12-нд ийлдэс эмчилгээ захиалж, эмчилгээ эхэлсэн байна. Урсан чоныг одоогоор олоогүй байна.

1.3 Мэрэгч амьтны сэжигтэй дуудлага:

12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ээс мэрэгч амьтны нийт 94 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс 14.9%-иар илүү байна



ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны галзуу өвчин:


Увс аймгийн Наранбулаг сумын Улаан-Үзүүр багийн “Улаан Гануу” гэдэг газар 12 дугаар сарын 09-нд малчин “Б”-ийн хотонд Галзуу өвчний шинж тэмдэгтэй 1 үнэг орж ирсэн тул устгаж, дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд 11-ны өдрийн шинжилгээний дүнгээр эерэг дүнтэй тодорхойлогдсон байна.

Эх сурвалж: ОБЕГ

Олон улсад:

Африкийн гахайн мялзан өвчин:

ОХУ-ын ХХААЯ-наас мэдээлснээр Ленинград хотын Лужский мужийн Цэцэрлэгт хүрээлэнд Африкийн гахайн мялзан өвчний улмаас 3 гахай өвчилж үхсэн тул хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Малын хэл хөхрөх өвчин:


Итали улсын Сардиния хотын нэгэн мужид малын хэл хөхрөх өвчний улмаас 142 хонь өртөснөөс, 1 хонь өвчилсөн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Гахайн сонгомол мялзан өвчин:

ОХУ-ын Приморский край хотод гахайн сонгомол мялзан өвчин бүртгэгдэж, 1 гахай өвчилж үхсэн тул, хязгаарлалтын дэглэм тогтоон, тандалт судалгаа хийгдсэн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Вакцинжуулалт: ОХУ-ын Московская муж

ОХУ-ын Московская мужид 61 хонинд хонины цэцэг өвчний вакцинжуулалт хийгдсэн тухай ДАЭМБ-аас мэдээлжээ.

Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:


БНХАУ-ын Shunyi дүүргийн гахайн аж ахуйд, африкийн гахайн мялзан өвчний улмаас 34757 гахай өртөмхий байснаас, 53 нь өвчилж, 26 гахай өвчилж үхэн, 34731 гахайг устгалд оруулж хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Гахайн сонгомол мялзан: Япон, Гифи муж

Япон улсын Сэки хотын Гифү мужийн гахай үржүүлгийн газар 23 гахай өртөснөөс, 1 гахай өвчилж үхэн, 22 гахайг устгаж тандалт судалгаа хийгдсэн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Тарваган тахал: Бүгд Найрамдах Мадагаскар улс (нөхцөл байдал):

Мадагаскар улсад 8 сар хүртлэх хугацаанд тарваган тахлын хүний өвчлөлийн 124 тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс булчирхайн хэлбэр 91(73.4%), уушгины хэлбэр 31(25%), үжил хэлбэр 1 тохиолдлыг тус тус эзлээд байна.

Эх сурвалж: <http://outbreaknewstoday.com>

Энэ долоо хоногт Архангай, Баян-Өлгий, Завхан, Ховд, Хөвсгөл, Төв аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн байна.

Бусад салбар төвүүд ШУН-ийн доорхи хаяг руу мэдээгээ ирүүлж байна уу?

eop@nczd.gov.mn

nczd.eop@gmail.com

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖ